

АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ (2017 он)

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201701/01. ИНЕГ-т. /Safety recommendation 201701/01. МСАА/. Агаарын тээврийн компаниудын нислэгийн үйл ажиллагааны зааварт хөндлөнгийн салхитай үед нислэг үйлдэх талаарх үйлдвэрлэгчийн заавар, зөвлөмжийг тусгуулан мөрдүүлэх арга хэмжээг авах

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201701/02. ИНЕГ-т. /Safety recommendation 201701/02. МСАА/. Агаарын тээврийн компаниудын нисгэх багийн шилжих, мэргэшүүлэх болон давтан сургалтын хөтөлбөрүүдэд хажуугийн өрөвхийлөлт бүхий хүчтэй салхитай үед нислэг үйлдэх дадлагажуурын сургалтыг үйлдвэрлэгчийн заавар, зөвлөмж, ашиглалтын хязгаарлалттай уялдуулан тусгуулан мөрдүүлэх арга хэмжээг авах

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201701/03. ИНЕГ-т. /Safety recommendation 201701/03. МСАА/. Орон нутгийн бүх нисэх буудлын цаг уурын автомат ажиглалтын төхөөрөмжийг (MAWS-301 г.м) Чикагогийн конвенцийн 3-р Хавсралт болон холбогдох Дос-ын шаардлагад нийцүүлэн байрлуулах арга хэмжээг авах

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201701/04. ИНЕГ-т. /Safety recommendation 201701/04. МСАА/. Орон нутгийн бүх нисэх буудлын цаг уурын автомат ажиглалтын төхөөрөмжийн (MAWS-301 г.м) ашиглалт, үйл ажиллагааг ИНД-174 дүрэмтэй нийцүүлэх арга хэмжээг авах

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201701/05. ИНЕГ-т. /Safety recommendation 201701/05. МСАА/. Агаарын хөлгийн явгалалт, хөөрөлтийн өмнө цаг агаарын мэдээлэлийг Чикагогийн конвенцийн 3 дугаар хавсралт болон Дос 4444 7.4.1.2.1, 7.4.1.2.2-д заасны дагуу нисгэх багт өгөх талаар нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын холбогдох зааварт тусгуулан мөрдүүлэх арга хэмжээг авах

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201701/06. МИАТ ХК-д. /Safety recommendation 201701/06. MIAT Mongolian Airlines /. Орон нутгийн бүх нисэх буудлын хөөрөх буух

зурвасны хажуугийн хязгаарын гэрлийн байрлал, суурийг стандартад нийцүүлэх

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201701/07. ИНЕГ-т. /Safety recommendation 201701/07. МСАА/. Чикагогийн конвенцийн 1-р Хавсралтын 1.2.4.5.1, 1.2.4.5.2 заалт болон ИНД 67.151 шаардлагыг хангасан этгээдийг шинжээч эмчээр томилох

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201701/08. ИНЕГ-т. /Safety recommendation 201701/08. МСАА/. ИНД-66 дүрмийн дагуу олгогдсон техник үйлчилгээний ажилтаны үнэмлэх эзэмшигчид EASA Part-145 дүрмийн дагуу эрх олгоход шаардлагатай ангилал, зэрэглэл болон олгогдох эрх, хязгаарлалтын талаар МОЕ заавартаа тодорхой тусгах

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201702/09. МИАТ ХК-д. /Safety recommendation 201702/09. MIAT Mongolian Airlines/. Агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн заавар, зөвлөмжийн хүрээнд бүхээгийн даралтын компьютерийг найдвартай ажиллагааны үзүүлэлт өндөртэй компьютерээр сольж сайжруулах

Аюулгүй ажиллагааны зөвлөмж 201702/10. МИАТ ХК-д. /Safety recommendation 201702/10. MIAT Mongolian Airlines/. Бүхээгийн даралтын компьютерийн санах ойг тогтмол үечлэлтэй татан авч шалгадаг болох

FAFIB